

2

МОНГОЛ УЛС ДАХЬ ГАДААД ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Б.Нацагдорж

Гадаадын хөрөнгө оруулалт нь улс хоорондын аж ахуйн харилцаа холбоог бэхжүүлэх үндсэн механизм бөгөөд санхүүгийн зах зээлийн даяарчлалын үйл явцад голлох байрыг эзэлж, түүний хөдлөх хүч болж байна. Гадаадын хөрөнгө оруулалт нь дэлхийн зах зээл дээр улс орнуудын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, энэ чанараараа гадаад худалдаа, бизнесийн үйл явцад хүчтэй нөлөөлөх боллоо.

Манай улсын гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд: "Гадаадын хөрөнгө оруулалт гэж /ГХО/ Монгол улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсвэл монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлийг хэлнэ" гэжээ. Уг хуульд ГХО-тай аж ахуйн нэгжийн нийт хөрөнгийн 25-аас доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийнх байхаар тогтоосон нь Олон улсын Валютын сан /ОУВС/-ын заасан 10%-ийн босгын шаардлагыг хангаж байгаа юм.

ОУВС-н тодорхойлсноор тухайн аж ахуйн нэгжид оруулж буй гадаадын хөрөнгө оруулалт нийт хөрөнгийн 10%-с доошгүйг эзэлж байвал гадаадын хөрөнгө оруулалттай компани гэж үздэг. Харин АНУ, Дани, Туркид 10%-аас, Финлянд, Франц, Испанид 20%-аас, Япон, Герман, Австри, Их Британид 25%-аас, Энэтхэгт 40%, Солонгост 50%, Мексикт 49%, Канадад 50%-аас багагүй, Нидерландад 100% байх жишээтэй.

Бага эдийн засагтай, хөрөнгө санхүүгийн чадамж, дотоод хуримтлал хэт хязгаарлагдмал Монгол орны хувьд гадаадын хөрөнгө оруулалт нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх нэгэн чухал эх үүсвэр мөн. Дэлхийн болон бүс нутгийн улам бүр өргөжиж, харилцан хамааралтай болж байгаа эдийн засгийн интеграцид тодорхой зорилго, чиглэлтэй оролцох шинэ боломжийг

гадаадын хөрөнгө оруулалт нээж өгдөг. Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг оруулах нь эдийн засгийн цаашдын өсөлтийг хангах хамгийн дөт зам болно. Үүнийг дагалдаж:

- дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх
- удирдлага, менежерийн мэдлэг чадварыг дээшлүүлэх
- хөрөнгийн урсгалыг дотогшоо чиглүүлэх
- өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, экспортыг нэмэгдүүлэх
- хадгаламжийг нэмэгдүүлэх
- гадаад зах зээлд нэвтрэх, өрсөлдөх чадвараа дээшлүүлэх
- ажил эрхлэлт болон бүтээмжийг өсгөх зэрэг ач холбогдолтой.

Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг татах давуу тал нь:

- улс төрийн тогтвортой байдал
- нээлттэй эдийн засгийн бодлого
- өргөн уудам нутаг дэвсгэр, эдэлбэр газрын ихээхэн нөөц
- эрдэс түүхийн арвин их нөөц
- мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц
- хил залгаа хоёр том гүрний болон дэлхийн олон улсын зах зээлийг ашиглах боломж
- хүн ам, хөдөлмөрийн нөөцийн залуужсан бүтэц, тэдний боловсролын түвшин, оюуны чадавхийг шинэ технологи, менежментийн арга ухаантай хослуулан ашиглах боломж
- олон улсын эдийн засаг, худалдаа, банк, хөрөнгө оруулалтын байгууллагын гишүүнчлэл зэрэг байх болно.

Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг татахад нөлөөлөх сул тал нь:

- дэд бүтэц, зам тээврийн хөгжил хангалтгүй, далайд гарцгүй
- аж ахуйн нэгжийн техник, технологийн түвшин хоцрогдол
- мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрчимжиж чадаагүй
- байгаль, цаг уурын эрс тэс, таатай бус нөлөөлөл
- үйлдвэрлэл, хэрэглээний таруу байршил нь бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалт, зардалд нөлөөтэй
- хүнд суртал, шат дамжлага, ажил хэрэгч чанарын дутагдал
- авилгал, хээл хахууль,
- харьцангуй цөөн хүн ам, мэргэжилтэй ажиллах хүчний хомсдол
- дотоодын хөрөнгийн хуримтлал бага, санхүүгийн нөөц хязгаарлагдмал

Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих үйл явц шилжилтийн үеийн эхэнд буюу 1990 онд худалдаа, үйлдвэрийн яамны дэргэд гадаадын хөрөнгө оруулалтын газар байгуулагдсанаар эхлэлээ тавьсан. Аливаа улс гадаадын хөрөнгө оруулалтыг татахын тулд эрх зүйн таатай орчинг бүрдүүлсэн хуультай байх асуудал чухал билээ. Энэ үүднээс Монгол улсын Их Хурал 1991 онд “Гадаадын хөрөнгө оруулалтын


тухай” хуулийг хэлэлцэж баталж, 1993, 1998, 2002, 2008 онуудад нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан. Мөн бусад холбогдох хууль тогтоомжуудыг баталж, гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг болоод хөрөнгө оруулалтыг дэмжих, урамшуулах асуудал тодорхой болсон юм. Улмаар 1996 онд уг асуудлыг хариуцсан “ Гадаадын хөрөнгө оруулалтын газар” нэртэй бие даасан байгууллага байгуулагдаж 1998 онд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг/ГХОГХА/ болж өөрчлөгдсөн байна. Агентлагийн гол зорилго нь Монгол улсад гадаадаас оруулах хөрөнгийг нэмэгдүүлэх, экспорт, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, нэг цэгийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдэж байна.

Үүний зэрэгцээ Монгол Улсын Засгийн газар нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хамгаалахад чиглэгдсэн олон улсын байгууллагад гишүүнээр элсэх, олон улсын гэрээ байгуулах ажлуудыг хийжээ. Гадаадын хөрөнгө оруулалт нь монгол улсын хуулиуд болон нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалагдсан. Үүний үр дүнд манай гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсээр байна.

Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээ /1990-2010 он/


Он	ГШХО / Мян ам \$/	Компанийн тоо	Он	ГШХО / Мян ам \$/	Компанийн тоо
1990	965	2	2001	131,741	354
1991	2,108	10	2002	186,846	390
1992	1,906	22	2003	203,734	692
1993	3,569	40	2004	247,589	778
1994	31,509	78	2005	316,839	971
1995	56,166	145	2006	366,543	1505
1996	71,358	190	2007	499,962	1609
1997	61,537	256	2008	708,922	1551
1998	83,487	279	2009	801,158	613
1999	94,824	339	2010	1,025,996	769
2000	103,870	293			
Нийт				4,840.318	10709

Тухайлбал: 1990-1993 онд хөрөнгө оруулалтын хэмжээ төдийлөн их биш (0.9-3.5 сая \$) өсөлт нь удаан байсан ба 1994-1996 онд (31.5-71.3 сая \$) онуудад эрс нэмэгдэж, 1998 оноос тасралтгүй нэмэгдсээр байна.



Монгол улсад 1990 оноос хойш гадаадын 104 орны 10709 аж ахуйн нэгж эдийн засгийн 20 гаруй салбарт үйл ажиллагаагаа явуулахаар бүртгүүлсэн байна.

Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын компаний тоо



ГХОГХА-ын мэдээгээр 1990-2010 онд манай улсад дэлхийн 104 орноос 4,840.318 мянган долларын хөрөнгө оруулалт хийгдсэн¹.

¹ Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг

Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, улсаар /1990-2010 он /


Улсын нэр	Мян ам \$	Хувийн Жин	Улсын нэр	Мян ам \$	Хувийн Жин
БНХАУ	2468.235	50,99	Сингапур	87,361	1.80
Канад	400.005	8,26	Их Британи	51,326	1.06
Нидерланд	294.081	6,08	Кейман арал	48,417	1.00
БНСУ	255.813	5,29	Цвейцарь	41,469	0.86
Вержини арлууд (УК)	222.438	4,6	Люксембург	34,647	0.72
Япон	138.570	2,86	Болгар	30,867	0.64
БНХАУ /Гонконг/	127.350	2,63	Герман	27,737	0.57
Бермуда	121.059	2,5	Вьетнам	24,352	0.50
АНУ	115.690	2,39	Австрали	22,622	0.47
ОХУ	108.250	2,24	Бусад	220,028	4.54
Нийт				4,840,318	100

Монгол улсад хийж буй хөрөнгө оруулалтаараа БНХАУ тэргүүлж, Канад, Нидерланд, БНСУ, Вержини арлууд (УК), Япон зэрэг нь дараагийн байрт орж байна.

БНХАУ-с хийгдэж буй ГШХО-ын хэмжээ, компанийн тоо аль алинаар нь тэргүүлж байна. Тус улсаас геологи, уул уурхай, барилга, барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа, нийтийн хоол, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн боловсруулалтын салбарт орох хөрөнгө оруулалтын хэмжээ өссөн байна. Канад улс эрдэс, түүхий эдийн хайгуул, алтны үйлдвэрлэлд голчлон хөрөнгө оруулж байна.

БНСУ-ын хөрөнгө оруулагчид манай үйлдвэрлэл, үйлчилгээний олон салбарыг сонирхох болж оруулсан хөрөнгийн хэмжээ жилээс жилд нэмэгдэж байна. Япон улсын хөрөнгө оруулагчид хөнгөн үйлдвэрлэл, харилцаа холбоо, соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл, худалдаа, нийтийн хоолны салбарт илүү хөрөнгө оруулалт хийжээ.

Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, улсаар



1990-2010 онуудад хийсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын 50.99 % нь Хятад улсад, 8,26% нь Канад улсад, 6,08% нь Нидерланд улсад, 5,29% нь БНСУ –д, 4,60% нь Вержини арлуудад (UK) , 2,86 % нь Япон улсад ноогдож байна. Монгол улс дахь гадаадын нийт хөрөнгө оруулалтын 78.08 % дээрх зургаан оронд ноогдож байна.

Үндэсний аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалд “Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрэхгүй байлгах бодлого баримтлана” гэж заасан. Үүнтэй уялдуулан Гадаад бодлогын үзэл баримтлалын 3 дугаар бүлэгт “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтыг үндэс болгон эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хараат байдалд орохоос сэрэмжилнэ” гэж заасан. Өдгөө Манай улс дахь гадаадын нийт шууд хөрөнгө оруулалтын 50,99 хувь нь, гадаадын компаниудын дийлэнх хувь нь БНХАУ-ынх байна.


Гадаад худалдаанд ч бас нэг тийш хэлбийх хандлага хүчтэй боллоо. Тухайлбал, 2010 оны байдлаар манай улсын экспортын 80 гаруй хувь нь БНХАУ-д, 3 орчим хувь нь ОХУ-д ногдож байна. Харин импортын хувьд харилцан тэнцвэртэй байгаа юм. Иймд цаашид гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны тэнцвэртэй, зохистой байдлыг хангах бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай. Гэхдээ үүнийг механикаар биш, харин эдийн засгийн уян хатан бодлогоор, алхам алхмаар хэрэгжүүлэх учиртай.

**Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ,
салбараар /1990-2010 он /**

№	Салбарын нэр	Мян.ам \$	Хувийн жин
1	Геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тос	3,158,716	65.3
2	Худалдаа, нийтийн хоол	913,702	18.9
3	Банк, санхүүгийн үйл ажиллагаа	131,390	2.7
4	Хөнгөн үйлдвэр	107,908	2.2
5	Инженерийн барилга байгууламж, барилгын материал	74,317	1.5
6	МАН-н гаралтай түүхийн эд боловсруулалт	55,411	1.1
7	Мэдээлэл,холбооны технологи	36,108	0.7
8	Тээвэр	28,039	0.6
9	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл	21,984	0.5
10	Аялал жуулчлал	18,871	0.4
11	Соёл урлаг, боловсрол, шинжлэх ухаан, хэвлэл	14,684	0.3
12	ХАА, газар тариалан, МАН	14,814	0.3
13	Эрүүл мэнд гоо сайханы үйлчилгээ	12,491	0.3
14	Мебель, модон эдлэл	5,887	0.1
15	Эрчим хүч	5,516	0.1
16	Нийтийн ахуйн үйлчилгээ	2,803	0.1
17	Үнэт зүйлс, бэлэг дурсгал	2,648	0.1
18	Цахилгаан хэрэгслийн үйлдвэрлэл	1,809	0.0
19	Гэр ахуйн хэрэгслийн үйлдвэрлэл	1,433	0.0
20	Бусад	231,785	4.8
	Нийт ГШХО	4,840,318	100

ГШХО-ыг салбараар авч үзвэл 1990-2010 оны нийт хөрөнгө оруулалтын 65,3% нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолтын салбарт, худалдаа нийтийн хоолны салбарт 18.9%, банк, санхүүгийн үйл ажиллагааны салбарт 2.7%, хөнгөн үйлдвэрт 2.2% ногдож байна.

Монгол улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ, салбараар



Уул, уурхайн салбар нь гадаадын хөрөнгө оруулалтын тэргүүлэх салбар бөгөөд БНХАУ, Канад зэрэг улсын хөрөнгө оруулагчид илүү сонирхож байгаа нь харагдаж байна. ГШХО - ыг салбараар авч үзвэл геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолтын салбарт хамгийн их хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд хөрөнгө оруулалттай компаний тоогоор худалдаа, нийтийн хоолны салбар тэргүүлжээ.

Худалдаа, нийтийн хоолны салбарт 6926 компани үйл ажиллагаа явуулахаар бүртгэгдсэн бөгөөд нийт гадаадын хөрөнгө оруулалттай компанийн 64.7% эзэлж байна. Бусад хөрөнгө оруулалтын салбарыг бодвол харьцангуй бага хөрөнгө оруулалт шаардагддаг нь харагдаж байна. Энэ салбарт хөрөнгө оруулалтын хэмжээгээр БНХАУ, БНСУ зэрэг орнууд тэргүүлж байна.

Иймд 2008 онд өөрчлөлт оруулсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулиар Монгол улсад орж буй хөрөнгө оруулалтын босгыг нэмж 100,000 ам доллар болгосон.

Гадаадын хөрөнгө оруулалттай нийт компани 70 орчим хувь нь манай аж ахуйн нэгжтэй хамтарсан, 30 орчим хувь нь 100 хувийн өөрийн хөрөнгө оруулалттай гадаадын компани байна. Гэвч гадаадын 100 хувийн хөрөнгө оруулалттай компани өсөх хандлагатай байгаа нь манай эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй.

Сүүлийн жилүүдэд гадаадын шууд хөрөнгө оруулалт хэмжээний хувьд өсч, улс орны эдийн засагт гүйцэтгэх үүрэг өсөн нэмэгдэж байна. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дагаж ДНБ өссөн төдийгүй ажил эрхлэлт, цэвэр экспортод нөлөөлөх болсон. ГШХО нь хэмжээний хувьд

өсөөд байгаа ч манай нийгэм эдийн засагт төдийлөн сайн нөлөө үзүүлж чадахгүй байна. Энэ нь “Голланд өвчин”, “Чөтгөрийн цагираг”- тай холбоотой юм.

Гадаадын хөрөнгө оруулалтыг татахад түлхүү анхаарах чиглэлүүд гэвэл:

- Гадаадын хөрөнгө оруулалтыг экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд чиглүүлэх
- Гадаадын хөрөнгө оруулах чиглэл, эрэмбэ дарааллыг эдийн засгийн өсөлт, бүтцийн өөрчлөлттэй уялдуулах
- Тодорхой салбарын хөгжил, үйлдвэрлэлд нэг орны оролцох хувь хэмжээг эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нөхцлийг бодолцон тогтоох
- Гадаадын хөрөнгө оруулалтыг боловсруулах болон капиталын багтаамж ихтэй үйлдвэрийн салбарт түлхүү оруулах
- Гадаадын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглүүлэх
- Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамруулах, хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг татварт хамруулах
- Гадаадын хөрөнгө оруулагчдад Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх үйл ажиллагаанд нь хяналт тавих дэг журмыг эхнээс нь нэг мөр хэвшүүлэх
- Тэдний орон нутгийн байршилд анхаарах
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулинд үндэсний үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах талаар тусгаж өгөх

Дүгнэлт

1. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь хэмжээний хувьд өсөөд байгаа ч Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд төдийлэн сайн нөлөө үзүүлж чадахгүй байна.
2. Гадаадын хөрөнгө оруулалтын улс орны бүтцийг авч үзвэл цөөн орны давамгайл байдал тогтоох хандлагатай байна. Иймд цаашид гадаадын хөрөнгө оруулалтын тэнцвэртэй, зохистой байдлыг хангах бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай.
3. ГШХО-ыг салбараар авч үзвэл 1990-2010 оны нийт хөрөнгө оруулалтын 65,3% нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, судалгаа, олборлолтын салбарт хуваарилагдсан байна. Байгалийн нөөц баялагийг олборлох,экспортлох чиг баримжаатай эдийн засгийн бүтэц үндэсний аж ахуй,нийгмийн амьдралын тогтвортой баталгаа болж чадахгүй байна
4. Төрийн бодлого зохицуулалтад онцгой анхаарах нэг асуудал бол гадаадын “хар буюу сүүдрийн хөрөнгө” оруулалтыг орж ирэхээс хатуу болгоомжлох түүний эсрэг хууль эрх зүйн зохицуулалтыг чангатгах явдал юм.
5. Монгол улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татахад эрх зүйн болон бизнесийн орчинг цаашид илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

Ном зүй.

1. Бороо З. Гадаадын шууд хөрөнгө оруулалт .УБ.,2004
2. Отгонсайхан Н. Олон улсын бизнес. УБ., 2009
3. Шагдарсүрэн А.Хөрөнгө оруулалтын эдийн засгийн асуудлууд. УБ., 2005
4. МУИС – ийн ЭЗС – ийн хамтын бүтээл “ Хөрөнгө оруулалтын бодлого, эрх зүйн зохицуулалт” 2005 он
5. МУ –ын гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль , 2008
6. ГХОГХА - н мэдээ, мэдээлэл
7. Charles W.L .Hill International business, Mc Graw Hill.,2005
8. [http:// www.google.mn /](http://www.google.mn/)